

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай сургалтын багц гарын авлага

Зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг дэмжих гарын авлагыг хүлээн авна уу. Энэхүү гарын авлага нь албан болон албан бус боловсролын орчинд, төрөл бүрийн аргаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар заахад туслах зорилготой юм.

Энгийн, хөгжилтэй дасгалуудаар дамжуулан багш, эцэг эхчүүд хүүхэд багачуудад замын хөдөлгөөнд аюулгүй оролцоход нь туслах боломжтой.

Энэхүү гарын авлага хүүхэд залуучуудад замын хөдөлгөөний аюулгүй байдлын суурь ойлголт, зарчмыг насны онцлогт нь тохирсон аргаар заахад шаардлагатай материалуудыг багтаасан болно.

Уг гарын авлагад орсон бүх дасгал, үйл ажиллагаа нь дараах гол зарчмуудад үндэслэгдсэн:

- Замын хөдөлгөөний тухай болон түүний аюул, ослын тухай **мэдлэг, ойлголт**
- Замын орчинд биеэ зөв авч **явах байдал**
- Өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангахын тулд **аюулгүй сонголт хийх**

Яагаад замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай заах хэрэгтэй вэ?


Дэлхий даяар өдөрт дунджаар 18 хүртэлх насны 500 гаруй хүн амь үрэгддэг байна. Зам тээврийн осол нь дэлхийн өнцөг булан бүрт амьдарч буй хүүхэд багачуудын амь эрсдэх хамгийн том шалтгаан болдог.

Иймд замын хөдөлгөөний аюулгүй байдал нь хүүхэд багачуудын хувьд амин чухал зүйл юм. Тэдэнд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх анхан шатны мэдлэг, дадлыг заах нь хэзээ ч эртдэхгүй. Жил бүр дэлхий даяар замын ослоор 1.2 сая гаруй хүн нас бардаг бол хэдэн арван сая хүн гэмтэж, тахир дутуу болдог.

Хүүхдүүд ялангуяа өндөр эрсдэлд өртдөг. Учир нь:

- Тэд жижиг биетэй учраас машиныг олж харах болон жолоочид анзаарагдахад бэрх байдаг.
- Тэд аюултай нөхцөл байдлыг төдийлөн сайн таньж мэддэггүй бөгөөд насанд хүрээгүй учир аюулгүй байдлаа сахих зөв шийдвэр гаргах чадвар нь бүрэн бүрэлдэж амжаагүй байдаг.
- Тэд бие махбодийн хувьд илүү жижиг учир гэмтэж бэртэх магадлал өндөр байдаг.





Багш, сурган хүмүүжүүлэгч нар хүүхдүүдэд амь насаа хамгаалах ойлголт мэдлэг, дадлыг зааснаараа тэднийг хамгаалж чадах юм. Хүүхэд, багачуудад эрсдэлийг таниулж, аюулгүй байх стратегийг зааж өгөх нь хүүхдийн хөгжлийн чухал хэсэг билээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал нь хүүхэд багачуудын анхаарлыг хандуулах чухал сэдэв. Хүн бүр замын хөдөлгөөнд оролцож, ямар нэгэн байдлаар зам тээврийн аюулгүй байдлын нөлөөнд амьдардаг учраас бүр бага балчир хүүхэд ч энэ тухай ямар нэгэн ойлголттой байдаг.

Сургалтын багцын танилцуулга

Энэхүү багц гарын авлагууд нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай ойлголт, биеэ авч явах дүрмийг танилцуулахын тулд сонирхолтой, оролцогчдыг идэвхжүүлэх үйл ажиллагааг багтаасан.

Тус багц нь гурван хэсгээс бүрдэнэ:

- 6-аас доош насныханд зориулсан
- 6 – 11 насныханд зориулсан
- 12 – 14 насныханд зориулсан

Бүлэг бүрийн сэдвүүд нь ямар насны бүлэгт зориулагдсанаас хамааран өөр өөр боловч тэдгээр нь бүгд дээрх үндсэн зарчмуудыг агуулдаг.

Сургалтын багцыг ашиглах заавар

Бүлэг бүр багш болон багийн ахлагч нарт зориулсан зөвлөгөө, танилцуулгаас гадна хүүхдийн насанд нь тохирсон материалуудыг агуулсан болно.

Эдгээр ерөнхий тайлбар, материалууд нь хүүхэд багачуудад зориулсан замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хичээлд шаардлагатай бүхий л мэдээллийг өгнө.


Энэхүү материалууд нь багшийн чиглэл дор хэрэгжүүлэх ДАСГАЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА, болон хүүхдүүдэд олшруулж тарааж өгөх ТАРААХ МАТЕРИАЛ зэрэг хэсгүүдээс бүрдэнэ.

Дасгал болон тараах материалууд нь хичээлд ашиглах ба сургуулиас гадуурх арга хэмжээнд хэрэглэх боломжтой замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай сургалтын хөтөлбөрийг бүрдүүлнэ. Долоо хоног бүр янз бүрийн үйл ажиллагаа зохион байгуулж, ямагт замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай ойлголтыг дахин дахин бататгана.

Эдгээр дасгал, тараах материалууд нь тус бүрдээ аюулгүй байдлыг хангах тухай мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд чиглэгдсэн учир мөн тус тусад нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын тодорхой нэг асуудлын хүрээнд ашиглах боломжтой.



ЗАМЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОВСРОЛ



12-14

Гол сургамжууд

Бүлэг бүрд агуулагдах багш нарт зориулсан тайлбар, тэмдэглэл нь тухайн насны бүлэгт зориулсан гол сургамжийг агуулахаас гадна дасгал бүр тодорхой сургамж, зорилготой. Эдгээр гол сургамжуудыг дахин дахин бататгах нь чухал.

Идэвхтэй суралцах

Хүүхдүүд идэвхтэй, оролцоотой байх үедээ илүү сайн сурдаг. Хичээлүүд дээрээ аль болох **харилцан хамтран ажиллаж**, амьдралд ойр байдлаар заахыг хичээгээрэй.

Бодит амьдралын туршлага

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай заахдаа танхимаас гадуурх практик үйл ажиллагаа зохион байгуулахыг хичээх хэрэгтэй.

Нэр томъёог ойлгох нь

Замын аюулгүй байдлыг ойлгохын тулд хүүхдүүд энэ асуудалтай холбоотой нэр томъёо, үг хэллэгийг сайн мэддэг байх нь чухал. Хүүхдүүд багшийн ашиглаж буй нэр томъёог ойлгож байгаа эсэхийг үргэлж хянах хэрэгтэй. Энэ нь бүх насны бүлгийн хүүхдүүдэд хамаатай ч бага насныханд бүр илүү чухал юм.

Онцлог, ялгаа

Тухайн насны бүлэгт хамаарч буй хүүхдүүд замын хөдөлгөөний талаар өөр өөр мэдлэг туршлагатай учраас үүнтэй уялдуулж дасгал, үйл ажиллагаагаа тохируулан өөрчлөх хэрэгтэй. Тухайлбал, зарим хүүхдийн гэр бүл машингүй, зарим нь засмал замгүй гудамжинд амьдардаг байх магадлалтай. Хот суурин болон хөдөө орон нутгийн хүүхдүүд өөр өөр асуудалтай тулгардаг учир тэдний хичээлийг заахад ч өөр өөр сэдвүүд дээр төвлөрөх шаардлагатай.

Мэдрэмжтэй байх


Бүлгийн ахлагч нь тухайн бүлэгтээ гэр бүлийн гишүүн нь эсвэл найз нь зам тээврийн ноцтой осолд өртсөн хүүхэд байгаа эсэхийг үргэлж шалгах хэрэгтэй. Ийм тохиолдолд онцгой мэдрэмжтэй байхыг шаардах бөгөөд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид урьдчилан сануулах нь тохиромжтой юм. Ингэснээр тэд хүүхдээ сургалтын үйл ажиллагаанд урьдчилан бэлтгэх боломжтой болно.

Эцэг эх, асран хамгаалагчдыг оролцуулах

Хүүхдүүдэд эцэг эхийн биеэ авч яваа байдал нь нөлөөлдөг учир замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалтад хүүхдүүдээс гадна эцэг эхчүүдийг оролцуулах нь чухал. Гарын авлагад багшийн зүгээс эцэг эхчүүдэд илгээх боломжтой хүүхдүүд нь юу сурч мэдсэн, сурсан зүйлээ хэрхэн бататгах тухай таниулах зорилготой захидал багтсан болно.

3





12-14 насныханд зориулсан удиртгал хэсэг

Гарын авлагын энэхүү бүлэг дараах гол агуулгыг хүргэнэ:
 Сонор сэрэмжтэй байж үргэлж аюул эрсдэлийг олж харах.
 Замын хөдөлгөөнтэй орчинд эрсдэлтэй үйлдэл бүү гарга.
 Замын аюулгүй байдал хүн бүрт хамаатай.
 Үе тэнгийнхний дарамт шахалтаас зайлсхий.
 Суудлын бүсээ үргэлж зүү.

Гарын авлагын энэхүү бүлэг нь 12-14 насныханд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар заахад чиглэгдэнэ. Энэ насныхан аюулгүй байх анхан шатны багагүй мэдлэгтэй болохоор тэдний анхаарлыг татахад хялбар биш. Тийм ч учраас тэд замын аюулгүй байдал зөвхөн бага насны хүүхдүүдийн асуудал гэж үзэх магадлалтай.

Гэсэн хэдий ч энэ бол маш чухал зорилтот насныхан билээ. Өсвөр насныхан бага насны хүүхдүүдийг бодвол илүү бие даасан байдаг ч замын осолд өртөн хүнд гэмтэх, амь насаа алдах хамгийн өндөр эрсдэлтэй бүлгүүдийн нэг юм. Замын хөдөлгөөний осол гэмтэл нь 10-24 насныхны хувьд үхлийн гол шалтгаан болдог.


Энэ насан дээр үүсч болзошгүй эрсдэлүүд нь янз бүрийн шалтгаанаар өөрчлөгдөж байна. Өсвөр насныхан бага насныхныг бодвол илүү эрсдэлтэй үйлдэл гаргах нь түгээмэл боловч томчуудтай харьцуулбал эрсдэлийг үнэлэх чадвар нь хангалтгүй байдаг. Түүнчлэн тэд өөрсдийн чадварыг хэт үнэлж, үе тэнгийнхнийхээ нөлөөнд автан эрсдэлтэй үйлдэл хийх магадлал их.

Энэ насныхантай ажиллах явцдаа замын аюулгүй байдал гэдэг нь үхэл болон хүнд бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх тухай учраас энэ асуудалд хариуцлагатай хандах ёстой гэдгийг ойлгуулах нь чухал.

Таны хичээл, заах арга зүй энэ насныхны хувьд тохирсон эсэхийг нягтлах нь зүйтэй. Тодруулбал:

- Өсвөр насныхан юуг аль хэдийн мэдэж байгааг судлан тогтоох, энэхүү мэдлэг дээр нь суурилан заах.
- Оролцоо, хэлэлцүүлгийг хөхүүлэн дэмжих.
- Өсвөр насныхны амьдрал, туршлагатай нь холбох.
- Бодит амьдралын дадал, практик даалгаврууд хийлгэх.





- Эрсдэлд орохын аюул болон зөв сонголт хийх талаар ярилцах.
- Хүүхдүүдэд өөрсдийнхээ үйлдлийн үр дагаврыг ойлгоход нь туслах.

Эхлэл

Аюул эрсдэлийг ойлгох

Энэ бүлэг дэх эхний дасгалууд болон тараах материал нь залуу хүмүүсийн анхаарлыг үүсч болзошгүй аюул эрсдэлд төвлөрүүлэхэд чиглэгдэнэ. Эдгээр дасгал нь залуу хүмүүсийг өөрсдийнхөө үйлдэлд анхаарах, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх болон зөвшөөрөхгүй хэм хэмжээний талаар эргэцүүлэхэд тусална.

ДАСГАЛ: “Эрсдэлтэй үйлдэл-Бүлгийн хэлэлцүүлэг” өсвөр насныхан өөрсдийнхөө үйлдлийг эргэцүүлэн бодож, эрсдэлтэй зүйлстэй холбоотой өөрсдийн байр суурь, хандлагыг сориход чиглэгдэнэ.

ДАСГАЛ: “Хэр зэрэг эрсдэлтэй вэ? Дасгал” дээрх сэдвийг үргэлжлүүлэх бөгөөд хүүхдүүд эрсдэлийн түвшинг үнэлж, асуудлыг хэлэлцэхэд тусална.

ТАРААХ МАТЕРИАЛ: “Аялалын төлөвлөлт” ба “ТАРААХ МАТЕРИАЛ: “Өөрийн аюулгүй байдлыг үнэлэх” эдгээр нь хүүхдүүдийн өдөр тутамдаа тулгардаг эрсдэлийн талаар хэлэлцэх, тэд юу сурснаа хэрэгжүүлэхэд зориулагдсан дасгалын хуудас юм.

Замын аюулгүй байдал хүн бүрт хамаатай

ДАСГАЛ: “Замын аюулгүй байдлын аян” энэ нь замын хөдөлгөөний орчинд хүүхдүүд өөрсдийгөө аюулгүйгээр биеэ авч явах тухай мэдлэгээ практик дээр ашиглаж, гол сургамжуудаа хэрэгжүүлэхэд чиглэгдсэн дасгал.

ТАРААХ МАТЕРИАЛ: “Үзэл бодлоо хэл” хүүхдүүдийг замын аюулгүй байдлын асуудал чухал болох талаар эргэцүүлэхэд туслах бүлгийн дасгал.

ТАРААХ МАТЕРИАЛ: “Шалтгаан ба үр нөлөө” хүүхэд залуучуудын гаргаж буй үйлдлийн үр дагавар, үр нөлөөг олон талаас олж харахад тусална.


Үе тэнгийнхний дарамт шахалтаас зайлсхийх

ДАСГАЛ: “Үе тэнгийнхний дарамт шахалт - Жүжигчилсэн дасгал” жүжигчилсэн тоглолтын хэлбэрээр явуулах энэхүү дасгал нь үе тэнгийнхний нөлөө, дарамт

5



ЗАМЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОВСРОЛ



12-14

шахалтын талаар ойлголт авах, түүнийг хэрхэн шийдвэрлэх стратеги, арга замыг олж харахад тусална.

Суудлын бүсээ үргэлж зүү

ТАРААХ МАТЕРИАЛ: Суудлын бүс. Энэхүү дасгалын хуудас нь суудлын бүс зүүх талаар хүмүүсийн дунд түгээмэл оршдог ташаа ойлголтуудын талаар мэдээлэл өгч, тэдгээрийг залруулахад тусална.

Жолоочийн үйлдэл

Доорх хоёр дасгал нь залуу жолооч нартай холбоотой асуудлыг танилцуулна. Залуу хүмүүсийг жолоо барьж сурахаас нь өмнө энэ асуудлыг ойлгуулж мэдүүлэх нь чухал.


ДАСГАЛ: “Жолоочийн үйлдэл” тодорхой асуудлаар, тухайлбал, суудлын бүс зүүх, хурдтай явах, анхаарал сарнисан үедээ жолоо мушгин гэмтэл учруулах гэх мэт асуудлаар хүүхдүүд судалгаа хийж товч илтгэл-танилцуулга хийнэ.

ДАСГАЛ: “Аюулгүй жолоодох тухай санал асуулга” жолооч нарын үйлдлийг ойроос ажиглан, үүсч буй асуудлуудыг хэлэлцэхэд чиглэгдсэн.

Дүгнэлт гаргах

ДАСГАЛ: “Үүрэг амлалтын карт хийх” энэ нь хүүхдүүдэд юу сурч мэдсэн талаараа дүгнэлт хийж замын аюулгүй байдалд дагаж мөрдөх зүйлийг биелүүлэх үүрэг амлалт өгөх боломжийг олгох сүүлийн дасгал.





ДАСГАЛ: ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ - БҮЛГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Багшид зориулсан тэмдэглэл: Энэ нь багшийн чиглэл дор гүйцэтгэх дасгал юм. Эдгээр тэмдэглэл нь бүлгийн удирдагчдад зориулагдсан бөгөөд хүүхдүүдэд тараахгүй.

Шаардагдах хугацаа: 30 минут

Гол сургамж: Өсвөр насныхан буюу залуу жолооч нар замын орчинд аюулгүйгээр биеэ авч явах, аюул осол, эрсдэлийг ойлгож мэдэх

Зорилт: Туршлагагүй, байгалиасаа эрсдэлд орох үйлдэл хийх хандлагатай байдаг залуу хүмүүст энэ байдал нь тэднийг замын аюул осолд өртүүлж болзошгүйг ойлгуулах.

Энэ хичээл нь бүлгийн хэлэлцүүлэг бөгөөд залуу хүмүүс замын орчны аюул эрсдэл бүхий үйлдлийг анхаарч, өөрсдийнхөө аюулгүй байдлыг хангахын тулд хэрхэн биеэ авч явах тал дээр төвлөрнө.

Залуучууд ихэнхдээ туршлага хангалтгүй байдаг учраас тэд аюул эрсдэлийг олж харах чадвар дутмаг, эрсдэлтэй үйлдэл хийх магадлал харьцангуй өндөр байдагийг судалгааны дүн харуулж буйг бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчдод тайлбарлана.


Залуу хүмүүс замын орчинд хамгийн эрсдэлтэй бүлэгт тооцогддог – замын хөдөлгөөний ослоор нас барсан болон бэртэж гэмтэгсдийн 30 гаруй хувь нь 25 хүртэлх насны залуус байдаг. Замын хөдөлгөөний осол гэмтэл нь 10-24 насныхны үхлийн гол шалтгаан юм.

Өсвөр насныхны анхаарлыг дор дурдсан асуудлуудад хандуулж, өөрсдөдөө болон найз нөхдөдөө эдгээрээс аль шинж, үйлдлүүд ажиглагддагийг асууна уу. Эдгээр үйлдэл нь тэднийг хэрхэн эрсдэлд оруулж болох вэ, тэд аюулгүй байдлаа хангахын тулд өөрсдийн үйлдлээ яаж засаж өөрчлөх вэ?

- Замын аюулгүй байдал бол зөвхөн бага насны хүүхдүүдийн асуудал гэж бодон замын хөдөлгөөний орчинд эрсдэлтэй үйлдэл гаргах.
- Хэт өөртөө итгэлтэй байж, анхаарал хандуулах хэрэггүй гэж бодох.
- Зам хөндлөн гарахдаа гар утас ашиглаж, чихэвч зүүх.
- Замын ойролцоо найзуудтайгаа үймэлдэх.




З А М Ы Н
А Ю У Л Г Ү Й
Б А Й Д Л Ы Н
Б О Л О В С Р О Л



12-14

- Машинаар зорчихдоо суудлын бүс зүүхгүй байх.
- Шөнө тод өнгийн хувцас өмсөхгүйгээр гарах, ингэснээр жолооч нарт харахад хэцүү болгох.





ДАСГАЛ: ХЭР ЭРСДЭЛТЭЙ ВЭ?

Багшид зориулсан тэмдэглэл: Энэ нь багшийн чиглэл дор гүйцэтгэх дасгал юм. Эдгээр тэмдэглэл нь бүлгийн удирдагчдад зориулагдсан бөгөөд хүүхдүүдэд тараахгүй.

Шаардагдах хугацаа: 30 минут.

Гол сургамж: Замын орчинд сонор сэрэмжтэй байж, биеэ аюулгүйгээр авч яв. Онцын шаардлагагүй эрсдэл бүү гарга.

Зорилт: Залуусын анхаарлыг өдөр тутмын үйл ажиллагаанд гарсан эрсдэлийн түвшинд хандуулж, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх болон зөвшөөрөхгүй хэм хэмжээг үнэлүүлэх.

Дараагийн хуудсан дээрх тайлбар буюу өгөгдсөн мэдээллийг хэвлээд хайчилбар хийнэ үү.


Хүүхдүүдийг жижиг бүлгүүдэд хуваагаад бүлэг бүрт мэдээлэл бүхий хайчилбаруудаа өгнө. Бүлэг бүр өгөгдсөн мэдээллийг хэлэлцээд бүлэгтээ холбогдох эрсдлийнхээ түвшинг үнэлнэ. Хэлэлцүүлгийн дараа хайчилбар бүхий мэдээллүүдийг доорх гурван үндсэн хэсэгт хуваах даалгавар өгнө:

- Бага эрсдэл – Би үүнийг хийж болох юм.
- Эрсдэлтэй байх талтай – Зөв шийдвэр биш.
- Маш эрсдэлтэй – Хэзээ ч бүү хий.

Бүх бүлгүүд хайчилбаруудаа гурван хэсэгт ангилсны дараа бүгдийг нь буцааж нэгдсэн бүлгийн хэлэлцүүлэг хийлгэнэ.

Хэсэг бүрт ямар картууд, яагаад оруулсныг асуугаарай. Бүлэг хооронд хариултуудыг хүүхдүүд харьцуулж, санал нэг байгаа эсэхийг нь тодруулах хэрэгтэй. Хэрэв тэд санал нэг биш бол шалтгааныг нь асууж ярилцаарай.





ДАСГАЛ: ХЭР ЭРСДЭЛТЭЙ ВЭ? (Үргэлжлэл)

Замын хашлаганы ойролцоо явж байхдаа утсаа шалгах

Сургуулиасаа орой тарах

Бараан хувцастай шөнө гадуур гарах

Автобусны зогсоол дээр найзуудтайгаа үймэлдэх

Цэцэрлэгт хүрээлэнд хөл бөмбөг тоглох


Зам хөндлөн гарахдаа чихэвчээр хөгжим сонсох

Жолооч хурдны хязгаарыг хэтрүүлэхийг дэмжих

Гэр лүүгээ хүргүүлэхдээ машины ар талд ойрхон тоглох

Суудлын бүсээ зүүхгүй байх





ТАРААХ МАТЕРИАЛ: Аялалын төлөвлөгч¹

Та сургууль гэр хоёрынхоо хооронд жилд ойролцоогоор 400 удаа явна. Энэхүү дасгал нь таныг өөрийн туулж буй энэхүү замд дахин анхаарал хандуулж, ирэх очих замдаа аль болох аюулгүй байх арга замыг олж харахад тусална.

Таны сургуульдаа хүрэх замыг харуулсан орон нутгийн газрын зураг олох эсхүл өөрөө дүрсэлнэ үү.

Дараах үе шатуудын дагуу өөрийнхөө туулж буй аялал/замд дүн шинжилгээ хийн аюул осол болон эрсдэлийг бууруулах арга замд анхаарахын тулд доорх хүснэгтийг ашиглаарай.

- Үе шат бүрт гарч болзошгүй аюул ослыг жагсаа (Таныг гэмтээж болзошгүй зүйлс).
- Аюул гаргах эрсдэл бүрийг үнэл - өндөр, дунд зэрэг, бага? (Эрсдэл үүсэх магадлал нь хэр вэ?)
- Эрсдэлээ хэрхэн багасгаж эсхүл арилгаж өөрсдийгөө аюулгүй байлгах талаар эргэцүүл.


Доорх жишээг ажиглаад хүснэгтийг бөглөөрэй.

Миний аялалын үе шат	Аюул осол	Эрсдэл	Аялалаа хэрхэн аюулгүйгээр зохион байгуулах вэ?
Гол замын засмал байхгүй хэсгээр алхах	Зам дээр явж буй машинд мөргүүлэх	Дунд зэрэг/өндөр	Замын зах хэсгээр урсгал сөрж алхах. Тод өнгийн хувцас өмсөх.
Автобусны буудал руу алхахдаа гол зам дагуух засмал зам дээр алхах	Туслах замаас гарч ирсэн машинд мөргүүлэх	Дунд зэрэг/бага	Сонор сэрэмжтэй байх. Утас эсхүл найз нөхдөөсөө болж анхаарлаа бүү сарниул. Чихэвч зүүхгүй байх.

¹ Энэ материал Английн Тээврийн Яамны "Think!" кампанит ажлын хүрээнд хэвлэгдсэн бөгөөд түүнийг дахин хэвлүүлэхэд зөвшөөрөл олгосонд талархаснаа илэрхийлье. <http://think.direct.gov.uk>



ЗАМЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОВСРОЛ



12-14

Автобусанд суух	Автобус гэнэт зогссоны улмаас унах эрсдэл	Бага	Суудал дээр суух эсхүл зогсож байгаа бол бариулаас барих
Автобусаас бууж сургууль руу явахдаа зам хөндлөн гарах	Тээврийн хэрэгсэлд мөргүүлэх	Дунд зэрэг	Автобус хөдлөөд явах хүртэл хүлээх. Харагдах орчин сайтай газраар зам хөндлөн гарах. Зам хөндлөн гарахаас өмнө зогс, ажигла, сонс.

ТАРААХ МАТЕРИАЛ: Аялалын төлөвлөгч

(үргэлжлэл)

Сургууль хүртэлх замдаа дүн шинжилгээ хийх зорилгоор доорх хүснэгтийг ашиглаарай

Миний аялалын үе шат	Аюул осол	Эрсдэл	Аялалаа хэрхэн аюулгүйгээр зохион байгуулах вэ?

12



European Bank
for Reconstruction and Development




Eastern Alliance for Safe
and Sustainable Transport



FIA FOUNDATION



GLOBAL SHAPERS
COMMUNITY
ULAANBAATAR



Хэрэв ямар нэгэн хэвийн бус зүйл тохиолдвол та юу хийх байсан талаар мөн бодоод үзээрэй. Тухайлбал:

- Хэрэв та хоцорч гараад яарч ирвэл яах вэ?
- Хэрэв та автобусаасаа эсхүл гэр лүү чинь хүргэх унаанаасаа хоцорвол яах вэ?
- Хэрэв найзууд чинь замын хажууд үймэлдэж байвал яах вэ?

ТАРААХ МАТЕРИАЛ: Аюулгүй байдлаа үнэл


Энэхүү дасгал нь танд хувийнхаа аюулгүй байдлыг үнэлж, замын орчинд үйлдлээ дүгнэхэд тусална.

Та доорх хүснэгтэд анхаарлаа хандуулж, эдгээрийг хэр давтамжтай хийдгээ тодорхойлно уу:

	Ховор	Үе үе	Үргэлж
Та замдаа хангалттай цаг төлөвлөдөг үү?			
Та шөнө гарахдаа тод харагдахаар хувцас өмсдөг үү?			
Та зам хөндлөн гарахдаа чихэвч зүүдэг үү?			



ЗАМЫН
АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН
БОЛОВСРОЛ




12-14

Та замын ойролцоо гар утсаа ашигладаг уу?			
Та зогсоолд байгаа машинуудын хоорондох зайгаар зам хөндлөн гардаг уу?			
Та замын хөдөлгөөн ажрахгүйгээр зам хөндлөн гардаг уу?			
Зам хөндлөн гарахдаа гүйдэг үү?			
Машинаар явж байхдаа та суудлын бүсээ зүүдэг үү?			

Та хүснэгтийг бөглөж дууссаны дараа өөрийнхөө хариултыг бүлгийнхэнтэйгээ харьцуулаад аюулгүй байдлаа хэрхэн дээшлүүлэх талаар эргэцүүлэн бодоорой.



ЗАМЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОВСРОЛ



12-14

ДАСГАЛ: Замын аюулгүй байдлын кампанит ажил

Багшид зориулсан тэмдэглэл: Энэ нь багшийн чиглэл дор гүйцэтгэх дасгал юм. Эдгээр тэмдэглэл нь бүлгийн удирдагчдад зориулагдсан бөгөөд хүүхдүүдэд тараахгүй.

Шаардагдах хугацаа: Дор хаяж 1-2 цаг.

Гол сургамж: Зогс, Ажигла, Сонс. Бага насны хүүхдүүд насанд хүрэгчдийн гараас хөтлө. Өнгөлөг хувцас өмс. Суудлын бүсээ үргэлж зүү.

Зорилт: Хүүхдүүдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай гол ойлголт мэдээллийг өгч, эдгээрийг бодит амьдрал дээр бататгах.

Өсвөр насныхныг бага насны хүүхдүүдэд зориулан замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар аян санаачлан зохион байгуулахыг уриал. Аян, түүнийг хэрхэн хийх тухай тэдэнтэй ярилц.

Кампанит ажлын үеэр хүүхдүүд ямар сэдэв, агуулга дээр илүү төвлөрөн анхаарах талаар яриагаа эхлүүлэх хэрэгтэй. Доорх сэдэв, агуулгын нэгийг тэд сонгож болох юм:

- Зогс, Ажигла, Сонс
- Том хүний гараас хөтлөх
- Тод өнгийн хувцас өмс
- Суудлын бүсээ үргэлж зүү

Хүүхдүүд сэдвээ сонгомогц жижиг бүлгүүдэд хуваагдах эсхүл өөрсдөө бие дааж кампанит ажилд зориулсан материалуудаа бэлтгэнэ. Тэд янз бүрийн хэрэгсэл ашиглаж болно, тухайлбал:

- Зурагт самбар
- Тоглоом болон амьдралд тохиолдсон түүх
- Зурагт хуудас
- Видео, нийгмийн мэдээллийн хэрэгсэл (нөөц материалын олдоцоос хамааран)


Хүүхдүүд үзэгч, сонсогчдоо хэрхэн татах, хүргэх гэж буй гол мэдээллээ төслийнхөө цөм хэсэгт байлгахад анхаарч буй эсэхийг нягтлах нь зүйтэй.

Хүүхдүүдийг чадах хэмжээгээрээ аль болохоор олон материалаар хангаж, материалаа бэлтгэхэд нь хангалттай цаг гаргаж өгөөрэй.

Хэрэв боломжтой бол уг ажлыг дууссаны дараа төслийг хүлээж авах бага сургууль, бага насны хүүхдийн бүлэгтэй холбоо тогтоогоорой.

15





ТАРААХ МАТЕРИАЛ: Санал бодлоо хэл²

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар залуучууд өөрсдийнхөө хандлагыг илэрхийлсэн ишлэлүүдийг дор оруулав.

Жижиг багт хуваагдаад тэдний үзэл бодлыг хэлэлцэнэ үү. Тэдний зөв үү? Та санал нэг байна уу, үгүй юу? Яагаад?

Том хүмүүс үргэлж зам бол аюултай, осолтой гэдэг. Мөн зам хөндлөн гарахдаа аюулгүй газраар болгоомжтой гарахыг анхааруулдаг. Харин өөрсдөө зам хөндлөн гарахдаа хаа хамаагүй газраар гардаг. Тэд өөрсдөө замын аюулгүй байдлын дүрмийг баримтлахгүй байхад би яагаад тэгэх шаардлагатай гэж?


Миний найзууд машины урд гүйж сахилгагүйдэг байсан. Би үүнийг тэнэг үйлдэл гэж бодсон ч бусдад айсан байгаагаа харагдуулахыг хүсээгүй. Иймд, би тэднийг дагасан. Гэхдээ ганц удаа л тэгэж байсан

Бага ангид бид замын аюулгүй байдлын талаар маш их зүйл сурч, хийж байсан. Энэ бүгд одоо нэг их чухал байхаа больсон, яагаад гэвэл би одоо жаахан хүүхэд биш. Мэдээд сураад авчихсан. Миний найз нөхдүүдийн хэн нь ч гэмтэж байгаагүй. Би санаа зовох шаардлагагүй гэж бодож байна.

Бидний амьдарч байгаа орчинд аюулгүй байх боломжгүй.

² Энэ материал Английн Тээврийн Яамны "Think!" кампанит ажлын хүрээнд хэвлэгдсэн бөгөөд түүнийг дахин хэвлүүлэхэд зөвшөөрөл олгосонд талархлаа илэрхийлье. <http://think.direct.gov.uk>





Санал бодлоо хэл (үргэлжлэл)


Хэдийгээр замын аюулгүй байдлын дүрмийг мэддэг ч бодит амьдрал дээр байнга санаж хэрэгжүүлдэггүй. Сургууль руу яарч явахад би зөвхөн цагтаа очихыг л боддог. Нэг өдөр зам хөндлөн гарахдаа дугуйгаар явж байсан хүнтэй яг мөргөлдөх гэж байсан. Миний аз таарсан байх.

Замын аюулгүй байдал гэнэ ээ? Би энэ талаар боддог ч үгүй. Энэ талаар өдөр тутам хэн нэгэн хутгалуулсан, буудуулсан талаар гардаг шиг сонин телевиз радиогоор сонсогддоггүй. Эдгээр зүйлс нь л намайг айлгадаг.

Миний бодлоор энэ талаар санаа зовох ямар ч хэрэг байхгүй. Хэрэв чамайг дайраад гарах бол дайраад л гарчихна. Та хэрвээ буруу цагт буруу газар байгаа бол үүнийг зогсоох ямар ч боломжгүй Тийм биз дээ?

Би машины ард суухдаа хэзээ ч бүсээ зүүдэггүй. Бүс зүүх маш тухгүй тэгээд ч би одоо бүс зүүхэд хэтэрхий том болсон. Гэтэл бүсээ зүүхгүй бол юу болдог талаар сурталчилгаа үзсэн чинь юм бодогдуулсан шүү. Би одоо үргэлж бүсээ зүүдэг. Та намайг дэндүү болгоомжилж байна гэж бодож байна уу?





ТАРААХ МАТЕРИАЛ: Шалтгаан ба үр нөлөө³

Доорх текстэд Бат хэмээх 13 настай хүү хэрхэн замын осолд орсон тухай өгүүлнэ. Ослын үйл явдлын тухай уншаад, доорх мэдээлэлийг ашиглан осолд холбогдсон өөр өөр хүмүүсийн харах өнцгөөс асуудлыг эргэцүүлэн бодоод үзээрэй.

Бат осолд орсон тухай

Даваа гаригийн өглөө. 13 настай Бат хүү сургууль руугаа яаран явж байлаа. Тэр хоцорч явсан бөгөөд найз Болд нь аль хэдийн сургууль дээр ирчихсэн тухай түүнээс мессеж авав. Болд Батыг аль болох хурдан сургууль дээр ирэхийг хүсч байлаа. Учир нь тэд хичээл эхлэхээс өмнө хамтдаа хөлбөмбөг тоглох байв.

Бат замын эсрэг талд өөрийн суух автобусаа олж харав. Тэр автобусны буудалд хурдан хүрэхийн тулд зам руу яарлаа. Гэтэл тэр хүүхдээ арынхаа суудалд суулгасан залуу ээжийн жолоодож явсан машинд шүргүүлчихэв.

Бат машиныг харсангүй, харин жолоочид зогсох цаг байсангүй.

Хөл болон толгойдоо гэмтэл авсан Бат эмнэлэгт яаралтай хүргэгдлээ. Түүнийг эдгээхэд нэлээд хэдэн сар шаардлагатай гэв.

Осол болсоны дараа Батад амарч тэнхрэхэд маш их цаг шаардлагатай болохоос гадна эдгэрсний дараа ч түүнд даалгавраа нөхөн хийж, хичээлээ гүйцэж авахад маш их цаг зарцуулах хэрэгтэй болов. Тэр сургуулийн улирлын дараах аялалаас хоцорч, найз нартайгаа цагийг хамт өнгөрөөж чадсангүй.

Осолд холбогдсон хүмүүсийн доорх тайлбарыг уншина уу. Хүн бүр юу бодож байгаа, тэдний амьдралд энэ үйл явдал хэрхэн нөлөөлсөн тухай мөн учирсан хохирол, үр дагаврын талаар эргэцүүлэн бодоорой.

Бат


“Би аль хэдийн хоцорсон байв. Болд аль хэдийнэ сургууль дээр ирчихсэн, хөл бөмбөг тоглохыг хүсч байгаа тухайгаа надад мессежээр хэлэх үед би автобус замын хажууд зогсох гэж буйг хараад түүнд амжиж суухаар гүйсэн. Нэг мэдэхэд би эмнэлэг рүү хүргэгдэж байлаа. Юу ч хийлгүй нилээн хэдэн сар болсон.”

Осол Батад хэрхэн нөлөөлөв? Дараах зүйлсэд анхаарлаа хандуулна уу:

³ Энэ материал Английн Тээврийн Яамны “Think!” компани ажлын хүрээнд хэвлэгдсэн бөгөөд түүнийг дахин хэвлүүлэхэд зөвшөөрөл олгосонд талархаж байна. <http://think.direct.gov.uk>



ЗАМЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОВСРОЛ



12-14

- Бат бие махбодироо гэмтсэн
- Эдгэртлээ Бат найз нартайгаа юу ч хийж чадахгүй
- Түүний сургуульдаа яваагүй цаг хугацаа
- Замын хөдөлгөөнд оролцохдоо Бат хэтэрхий өөртөө итгэлтэй байна
- Батын цаашдын үйлдлийг энэхүү осол хэрхэн өөрчилж чадах вэ?
- Бат болон түүний найзууд хоорондын харилцаа

Болд

‘Би аль хэдийнэ сургууль дээрээ ирчихсэн, уйдаад байсан. Бат эрт ирнэ гэж амласан болохоор бид хичээлээс өмнө хөл бөмбөг тоглох байсан юм. Гэтэл Бат хоцорсон. Би үнэхээр тоглохыг хүсч байсан болохоор осол болохоос өмнө би түүн руу хурдал гэж мессеж бичсэн. Тэр амь насаа алдчихаагүйд л би маш баяртай байна.’

Осол Болдод хэрхэн нөлөөлөв? Дараах зүйлсэд анхаарлаа хандуулна уу:

- Батыг яаруулсныхаа төлөө Болд хариуцлагаа мэдэрч ойлгож байна уу
- Болд Бат нарын найз нөхөрлөлийн харьцаа хэрхэн өөрчлөгдөж болох вэ
- Батын найзууд Болдын талаар юу бодох бол
- Цаашид Болд биеэ авч явах байдлаа хэрхэн өөрчлөх вэ

Батын ээж

‘Бат сургууль руу яарч явахдаа мөргүүлсэн. Би түүнд зам дээр болгоомжтой бай гэж үргэлж хэлдэг. Азаар машин хурдтай яваагүй байсан, тэр өвдгөө гэмтээж, толгойгоо цохиж, оёдол тавиулах шаардлагатай болсон. Сургуулиасаа нэлээн хугацаагаар завсардсан.’

Осол Батын ээжид хэрхэн нөлөөлөв? Дараах зүйлсэд анхаарлаа хандуулна уу:

- Тэр хүүгээ осолд буруутгаж байна уу
- Цаашид Батын ээж түүнд хийхийг зөвшөөрөх зүйлс
- Батыг ганцаараа гараад явахад нь ээж нь хэрхэн хандах бол
- Бат осолд орсон гэсэн мэдээг утсаар сонсоод, мөн эмнэлэгт Батыг хараад тэр ямархуу байдалтай байв


Машины жолооч

‘Үнэхээр аймшигтай байсан. Хүү яг миний өмнүүр ороод ирсэн. Би машинаа зогсоож чадаагүй түүнийг мөргөчихсэн. Би арын суудалд сууж явсан жаахан хүүдээ дуу дуулж явсан, магадгүй бага зэрэг анхаарал сарнисан байх, гэхдээ энэнээс болоогүй гэж бодож байна. Хэзээ ч 100 хувь итгэлтэй байх боломжгүй шүү дээ. Миний толгойд байнга л энэ бодогддог. Би удаан явж байсан нь сайн болсон. Хэрэв би хурдтай явсан бол хөвгүүнийг алах байсан.’

19



ЗАМЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОВСРОЛ



12-14

Осол машины жолоочид хэрхэн нөлөөлөв? Дараах зүйлсэд анхаарлаа хандуулна уу:

- Жолооч Батад тохиолдсон явдалд зарим талаар өөрийгөө зэмлэж байгаагаараа өөрийгөө буруутай гэж үзэж байгаа эсэх
- Цаашид жолоо барихдаа өөртөө итгэлтэй байх эсэх
- Түүний машиныг засахад шаардагдах үнэ өртөг, цаг хугацаа
- Жолоочийн найзууд, гэр бүлийнхэн түүний тухай болон түүний жолоочийн ур чадварын тухай юу бодох вэ.


Цагдаагийн ажилтан

'Иймэрхүү осол замын хөдөлгөөнд оролцож буй ялангуяа залуу хүмүүст хэтэрхий их тохиолдож байна. Явган зорчигч, дугуйгаар зорчигч, жолооч гэх мэт. Энэ хөвгүүн азтай байна. Жаахан хурдтай л явсан бол магадгүй түүний амь үрэгдэх байсан байх.'

Осол цагдаагийн ажилтанд хэрхэн нөлөөлөв? Дараах зүйлсэд анхаарлаа хандуулна уу:

- Замын хөдөлгөөнд оролцогч залуу хүмүүсийн тухай тэр юу бодож байна вэ
- Түүнд ослын газар дээр ирээд ямар мэдрэмж төрөв
- Ослын тухай Батын ээжид хэлэх үед тэр ямар байдалтай байв
- Тэр өөрийнхөө хүүхэдтэй хэрхэн яаж харьцахад нь энэ осол яаж нөлөөлөх бол.





ДАСГАЛ: Үе тэнгийнхний дарамт шахалт - Жүжигчилсэн тоглолт⁴

Багшид зориулсан тэмдэглэл: Энэ нь багшийн чиглэл дор гүйцэтгэх дасгал юм. Эдгээр тэмдэглэл нь бүлгийн удирдагчдад зориулагдсан бөгөөд хүүхдүүдэд тараахгүй.

Шаардагдах хугацаа: 1 цаг орчим (бүлгийн тооноос хамаарна).

Гол сургамж: Үе тэнгийнхнийхээ нөлөө, дарамтанд бүү ор.

Зорилт: Жүжигчилсэн тоглолт ашиглах замаар залуу хүмүүст үе тэнгийнхний нөлөө, дарамтын асуудлыг олж харах, энэхүү асуудалтай нүүр тулах стратегийн талаар мэдээлэл олгох.

Энэхүү дасгалын хүрээнд оролцогчид 3-5 минутын богино жүжигчилсэн үзүүлбэр үзүүлнэ.

Хэрэв олон хүнтэй томоохон бүлэг байвал тэднийг 5-6 бүлэгт хуваахыг зөвлөө.

Замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой үе тэнгийнхний нөлөө, дарамтыг баримт нотолгоотойгоор оруулсан жүжигчилсэн үзүүлбэр зохиох зааврыг залуучуудад өгнө. Жүжгийн зохиолд эрсдэлтэй, аюултай үйлдлийн жишээ, эрсдэлтэй үйлдэл хийх дарамт шахалтад орсон залуусын жишээг багтаана.

Бүх залуус үе тэнгийнхний дарамт шахалтын талаар дэлгэрэнгүй ойлголттой болох хэрэгтэй. Тэднийг жүжигчилсэн үзүүлбэр дээрээ ажиллаж эхлэхээс нь өмнө тодорхой жишээн дээр нь ярилцаж, холбогдох мэдээллийг өгөх нь чухал.


Жүжгийн зохиол бүрт дараах зүйлсийг багтаана:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар гол сургамж
- Үе тэнгийнхний дарамт, шахалт, нөлөөг таньж мэдэн, аюултай үйлдэлд хийхээс зайлсхийх стратеги
- Үе тэнгийнхний дарамт шахалтын үр дагавар

Зохиолоо бодож бичихэд хүүхдүүдэд 15-20 минут өгөөд, дараа нь тэд жүжгийн сургуулилтаа хийнэ. Энэ хугацаанд багш бүлгүүдийг эргэж тойрон хүүхдүүд өгөгдсөн даалгаврыг хийхдээ зөв чиглэлд явж байгаа эсэхэд хяналт тавина.

⁴ Энэ материалыг Английн Баруун Иоркшайр Гал командын байгууллага хэвлэсэн бөгөөд түүнийг дахин хэвлүүлэхэд зөвшөөрөл олгосонд талархал илэрхийлье. www.westyorksfire.gov.uk






Хүүхдүүдэд бэлтгэл хийх цаг өгсөний дараа тэд өөрсдийнхээ богино хэмжээний жүжгийг бие биедээ тоглож үзүүлнэ.

Жүжиг бүрийг толилуулсны дараа доорх санаануудыг ярилцан хэлэлцэнэ:

- Асуудал үүсэхэд хүргэсэн эрсдэлтэй үйлдэл нь юу байв?
- Үе тэнгийнхний ямар хэлбэрийн дарамт шахалт илт харагдаж байна вэ?
- Найз нөхөрлөлийн холбоонд тухайн үйл явдал нөлөөлсөн үү?
- Хүмүүст болон эд хөрөнгөд гэмтэл, хохирол учирсан уу? Эдгээр нь хүн бүрт хэрхэн нөлөөлөв?
- Оролцогчид хэрхэн үйлдлээ өөрчилж болох вэ? Сайн үр дүнд хүрэхийн тулд тэд үйлдлээ хэрхэн өөрчилж чадах байсан бэ?






ТАРААХ МАТЕРИАЛ: Суудлын бүс⁵

Суудлын бүс нь хүний амь насыг авардаг: Бүс бүслэх энгийн үйлдэл нь замын аюулгүй байдлыг хангах бусад арга хэрэгсэлтэй харьцуулахад хэд дахин олон хүний амь насыг авардаг. Бүсээ бүслэхгүй байхыг одоо ч гэсэн зөвтгөж байна уу? Доор дурдсан зөвтгөх нийтлэг шалтгаан нь яагаад буруу вэ гэдгийг дараах хүснэгтээс үзнэ үү.

Би зөвхөн тэр булан хүртэл л явна, маш аажуухан явна.	➔	Ихэнх осол гэрээс 4 км-ийн зай дотор, 60 км/цаг-аас бага хурдтай явахад гардаг.
Суудлын бүс тухгүй, бие барьдаг.	➔	Суудлын бүс эхний үед тухгүй санагдавч дараа нь дасна. Бүс нь бие барих, хөдөлгөөн хязгаарлах нь зүйн хэрэг!
Би ар талд сууж явна. Зөвхөн урд сууж буй хүмүүст л суудлын бүс хэрэгтэй.	➔	Арын суудлын бүс зүүгээгүй зорчигчид өөрсдийгөө төдийгүй урд суугаа зорчигчдыг ч аюулд учруулдаг. Мөргөлдөх үед тэд урд суудал руу шидэгдэх эсхүл бусад зорчигчийг мөргөх магадлалтай.
Хэрэв би осолд орлоо гэхэд, жишээ нь, машин шатах, эсхүл усанд живсэн тохиолдолд суудлын бүс намайг урхидана.	➔	Ус болон галтай холбогдсон аваар осол нийт ослын нэгээс доошгүй хувийг эзлэнэ. Иймэрхүү осолд бүсгүй бол гал усны аюулд өртөхөөсөө бүр өмнө нь бэртэл гэмтэл авна, эсхүл амь үрэгдэнэ. Хэрэв шаардлагатай бол бүсээ сулруулж болно.
Осол аваарын үед бүс таныг гэмтээж өвтгөнө.	➔	Бүсгүй үед өвдөхөөс илүү өвтгөнө гэж байхгүй. Бүс нь таныг суудалд тань бэхэлж, машин дотор юм мөргөх эсхүл гадагш шидэгдэхээс хамгаална. Осол аваарын үед машинаас шидэгдсэн хүмүүсийн 75 хувь нь амь үрэгддэг. Суудлын бүс цөөн тохиолдолд л ноцтой бэртэл гэмтлийн шалтгаан болдог.

⁵ Энэхүү материалыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө Залуучууд байгууллага хэвлэсэн бөгөөд түүнийг дахин хэвлүүлэхэд зөвшөөрөл олгосонд талархал илэрхийлье. www.youthforroadsafety.org





ДАСГАЛ: Жолоочийн биеэ авч явах байдал

Багшид зориулсан тэмдэглэл: Энэ нь багшийн чиглэл дор гүйцэтгэх дасгал юм. Эдгээр тэмдэглэл нь бүлгийн удирдагчдад зориулагдсан бөгөөд хүүхдүүдэд тараахгүй. Уг дасгалыг хийхэд интернет холбоо шаардлагатай.

Шаардагдах хугацаа: 1 цаг хүртэл.

Гол сургамж: Суудлын бүсээ үргэлж зүү. Жолоо барих явцдаа гар утсаар хэзээ ч бүү ярь. Согтуугаар жолоо барьж болохгүй. Хурд бүү хэтрүүл.

Зорилт: Залуу жолооч нарт нүүрлэж буй асуудлуудыг өөрсдөөр нь судлуулж, ойлгуулах, жолооч болохоос нь өмнө тэдэнд эерэг хандлага, дадлыг суулгаж хөгжүүлэхэд нь туслах.

Залуусыг хэд хэдэн бүлэгт хуваагаад, жолоочийн үйлдэлтэй холбоотой сэдвийг судлуул. Энэ дасгалыг хийхэд интернетэд холбогдох хэрэгтэй болно. Бүлэг бүр авсан сэдвээрээ хоёр минутын мэдээлэл/презентаци бэлтгэнэ. Хамгийн тохиромжтой хувилбараар бол дөрвөн бүлэг болоод дараах дөрвөн сэдвийг авна.


- Аливаа нөлөөн дор жолоо барих – архи, хар тамхи хэрэглэсэн, хэт ядарсан үедээ гэх мэт
- Суудлын бүс
- Хурд хэтрүүлэх
- Анхаарал нь сарнисан үед жолоо барих – утсаар ярингаа, юм идэж байхдаа жолоо барих гэх мэт

Тэд дараах хүчин зүйлсийг анхаарах нь зүйтэй:

- Оршин сууж буй улсад мөрдөгдөж буй одоогийн хууль? Тус хуулийг чангатгах хэрэгтэй юу?
- Замын хөдөлгөөний осол, зөрчлийн дүн мэдээ
- Оршин сууж буй улсад болон дэлхий даяар явуулж буй замын хөдөлгөөний аюулгүй байдлын кампанит ажил



ЗАМЫН
АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН
БОЛОВСРОЛ




12-14

- Залуу хүмүүс нөхцөл байдалд хэрхэн нөлөөлж чадах вэ?
- Энэ асуудлаар жолооч нарын боловсролыг хэрхэн яаж дээшлүүлэх вэ?

Бүлгүүд бэлэн болсны дараа бүлэг бүр өөрсдийн бэлтгэсэн презентацийг бусдадаа танилцуулна.





ДАСГАЛ: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх санал асуулга

Багшид зориулсан тэмдэглэл: Энэ нь багшийн чиглэл дор гүйцэтгэх дасгал юм. Эдгээр тэмдэглэл нь бүлгийн удирдагчдад зориулагдсан бөгөөд хүүхдүүдэд тараахгүй.

Шаардагдах хугацаа: Санал асуулгад 1 цаг орчим, үргэлжлүүлэн хийх дасгал, үйл ажиллагаанд нэмэлт цаг орно.

Гол сургамж: Суудлын бүс үргэлж зүү. Жолоо барих явцдаа гар утсаар хэзээ ч бүү ярь.

Зорилт: Залуус замын хөдөлгөөнийг өөрийн биеэр ойроос ажиглаж, жолоочийн аюулгүй болон аюултай үйлдлийн талаар эргэцүүлэх.

Энэхүү дасгалын хүрээнд хүүхдүүдийг жижиг бүлэгт хуваагаад орон нутгийн замын уулзваруудад аваачин замын хөдөлгөөнийг 20 минутын хугацаанд ажиглуулж жолоочийн аюулгүй үйлдлийн талаар эргэцүүлэн бодуулах. Хүүхдүүдийг жолоодож сурахаас нь өмнө тэдэнд аюулгүй жолоодох тухай мэдлэг ойлголтыг заах нь маш чухал юм.

Хүүхдүүд зогсоход аюулгүй мөн хөдөлгөөний урсгал жигд байгаа зам эсхүл уулзварыг сонгоно.

Дасгалыг эхлэхээс өмнө доор дурдсан анхаарал түлхүү хандуулах зүйлсийн талаар ярилцана:

- Жолооч нар суудлын бүсээ зүүгээгүй байдал
- Зорчигчид суудлын бүсээ зүүгээгүй байдал
- Жолооч нар гар утас хэрэглэж байгаа байдал
- Аюултай жолоодлого: тухайлбал уулзваруудад зогсохгүй байх, машинууд буруу эгнээнд байрлах, хурдтай явах гэх мэт


Нэг эсхүл хоёр асуудалд төвлөрөх нь хамгийн зөв хувилбар байна. Бүлэг бүр мэдээллээ цуглуулах судалгааны буюу санал асуулгын хуудсаа бэлэн болгоно.

Санал асуулгын дараа

Бүлгүүд хамтдаа олсон мэдээллээ үндэслэн тайлан бичнэ. Тэд мэдээлэлдээ дүн шинжилгээ хийнэ, жишээ нь: жолооч нарын хэдэн хувь нь суудлын бүс зүүсэн, хэдэн



ЗАМЫН
АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН
БОЛОВСРОЛ




12-14

хувь нь зүүгээгүй байсан талаар гэх мэт. Олсон мэдээллүүдээ график болон хүснэгтээр танилцуулна.

Үргэжлүүлэн хийх төсөл буюу ажил

Хүүхдүүдэд жолооч нарыг суудлын бүсээ зүүх эсхүл жолоодох явцдаа гар утас хэрэглэхгүй байхыг дэмжсэн кампанит ажил бодож сэдэхийг даалгавар болгон өгөөрэй.





ДАСГАЛ: Үүрэг амлалтын карт хийх⁶

Багшид зориулсан тэмдэглэл: Энэ нь багшийн чиглэл дор гүйцэтгэх дасгал юм. Эдгээр тэмдэглэл нь бүлгийн удирдагчдад зориулагдсан бөгөөд хүүхдүүдэд тараахгүй.

Шаардагдах хугацаа: 45 минут.

Гол сургамж: Хүүхдүүдээр өөрсдөөр нь шийдүүлэх.

Зорилт: Замын аюулгүй байдлын гол чухал мэдээллийг хүргэх, хүүхдүүдийн өөрийнх нь үйлдэл нь тэднийг аюулгүй байлгахад нь тусална гэдгийг ойлгуулах.

Замын аюулгүй байдлын тухай амлалтын карт буюу зурагт хуудас хийх нь бүлгээр хийх дасгал юм. Гол санаа нь бүлгээрээ замын аюулгүйн дүрмийг хэлэлцэж, түүнийг биелүүлэх үүрэг амлалт авах бөгөөд амлалтын карт хийж түүн дээрээ гарын үсгээ зурна.

Бүлэг бүр дүрмийн болон амлалтын жагсаалтаа өөрсдөө гаргах бөгөөд үүнийг бүлгийн хэлэлцүүлгээр дамжуулан хийнэ. 5-8 зүйлээр амлалт гаргах ба аль нь хамгийн чухал болохыг эргэцүүлэн бодно.

Хүүхдүүд амлалтаа бодож гаргасны дараа гарын үсэг зурахын тулд картуудаа тус тусад нь хийх, эсхүл бүлгийн том зурагт хуудас хийн бүгд түүн дээр гарын үсгээ зурна.

Доор амлалтын картын загварыг толилуулж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай амлалтын карт

6


Амлалт

- Суудлын бүсээ зүү
- Замын ойр орчимд хэзээ ч бүү үймэлд
- Зам хөндлөн гарахдаа гар утас хэзээ ч бүү ашигла
- Жолоочийн анхаарлыг бүү сарниул
- Шөнө тод өнгийн хувцас өмс

⁶ Энэ материалыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө Залуучууд байгууллага хэвлэсэн бөгөөд түүнийг дахин хэвлүүлэхэд зөвшөөрөл олгосонд талархал илэрхийлье. www.youthforroadsafety.org



ЗАМЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОЛОВСРОЛ



12-14

Эрхэм хүндэт эцэг, эхчүүд ээ

Эдүгээ таны хүүхэд зам дээр гардаг олон тооны осол, гэмтлийг бууруулах зорилго бүхий Төслийн хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай суралцаж байна.

Хүүхдүүд төрөл бүрийн дасгал, үйл ажиллагаанд, тухайлбал, тоглоом, бүтээлч даалгавар, түүхээсээ хуваалцах, практик дасгалд гар бие оролцсон билээ.

Эдгээр нь тэдэнд замын хөдөлгөөний орчин тойронд хэрхэн аюулгүй байдлаа хангах талаар заахын сацуу доорх агуулга дээр төвлөрч байна:

Сонор сэрэмжтэй байж, аюул эрсдэлийг үргэлж хар.

Замын ойр орчимд эрсдэл бүү гарга.

Замын аюулгүй байдал хүн бүрт хамаатай.

Үе тэнгийнхний дарамт шахалтаас зайлсхий.

Суудлын бүсээ үргэлж зүү.

Өсвөр насныхан бага насны хүүхдүүдийг бодвол томрох тусмаа илүү биеэ даадаг. Тэд илүү эрсдэл гаргах хандлагатай ба чадвараа хэт үнэлэх, бусад үе тэнгийн хүүхдүүдийн нөлөөнд автан аюулгүй үйлдлийн хил хязгаараа эвдэх тохиолдол бий. Иймд энэ насныхан замын хөдөлгөөнд оролцогчдын дунд өндөр эрсдэлт бүлгийн нэг юм.

Энэхүү төсөл нь залууст замын ойр орчимд биеэ зөв авч явахын ач холбогдлыг ойлгуулах, аюул осол, эрсдэлийг дүгнэж цэгнэх чадварыг нь нэмэгдүүлэх, тэдэнд үе тэнгийнхнийхээ дарамт шахалтыг таньж мэдэх, түүнийг сөрөхөд нь туслах зорилготой билээ.

Эцэг эхийнх нь хувьд та бүхэн хүүхдүүддээ үлгэр жишээ болох ёстой. Мөн зам дээр болон тээврийн хэрэгсэл ашиглахдаа хүүхдүүддээ өөрийн биеэр үлгэр дууриалал үзүүлэх нь тэдэнд аюулгүй байх дүрэм, журам, чадварыг сургахад туслах төдийгүй, эдгээрийг тэд амьдралынхаа турш дагахад дэм болно.


Таны туслалцаа, дэмжлэгт талархал илэрхийлье!

“ZEBRA” төсөл

29



ЗАМЫН
АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН
БОЛОВСРОЛ



12-14

ТАЛАРХАЛ

Зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг дэмжих Аюулгүй, Тогтвортой Зам Тээврийн Дорнын Холбоо “АТЗТДХ” нь энэхүү гарын авлагыг бэлтгэхэд тусалж дэмжсэн дараах байгууллагуудад гүн талархал илэрхийлж байна.



Брейк, Замын аюулгүй байдлыг дэмжих байгууллага
www.brake.org.uk болон www.roadsafetyweek.org



European Bank
for Reconstruction and Development

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк
www.ebrd.com



FIA Сан
www.fiafoundation.org



Английн Зам Тээврийн Яам, Think! Кампанит ажил
think.direct.gov.uk



Замын аюулгүй байдлын төлөөх залуус байгууллага
www.youthforroadsafety.org

30

